



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 5/94

Улаанбаатар хот

«Ажилтны ур чадварыг үнэлэх, ур чадварын нэмэгдэл
олгох журам батлах, ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Соёлын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/166, А/63, А/73 дугаар тушаал, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 63/104 дүгээр тушаал, Сангийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 74 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт, Монголын Үндэсний музейн дүрмийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтны ур чадварыг үнэлэх, ур чадварын нэмэгдэл олгох журмыг энэхүү тушаалын Хавсралтаар баталсугай.

2. Ажилчдын ажлын ур чадварыг холбогдох шалгуурт үндэслэн улирал бүр үнэлж дүгнэх, ур чадварын нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох эсэх асуудлын талаарх саналыг Захиралд улирал бүр ирүүлж байх үүрэг бүхий ажлын хэсгийг Захиргааны зөвлөл буюу дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Зөнбилэг /Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга/

Гишүүд:

Д.Мөнхтоогоо

/Музей судлал, мэргэжил арга зүйн төвийн дарга/

Ч.Туулцэцэг

/Эрдэм шинжилгээний төвийн дарга/

Э.Оюунтуяа

/Сан хөмрөгийн албаны дарга/

Ц.Оюунхишиг

/Боловсрол, олон нийтийн хөтөлбөр, маркетингийн албаны
Дарга/

Н.Эрдэнэтуяа

/Аюулгүй байдал, үйлчилгээний албаны дарга/

М.Мөнгөнцэцэг


/Хүний нөөцийн ажилтан/

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлын хэсгийн нэгдсэн саналыг улирал бүр захиралд танилцуулж байхыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга (Т.Зөнбилэг) -д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монголын Үндэсний музейн захирлын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн "Ур чадварын нэмэгдэл олгох" тухай Б/29 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЭНХБАТ



1424000189

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ МУЗЕЙН АЖИЛТАНД УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Журмын агуулга:

1. Нийтлэг үндэслэл
2. Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт
3. Ур чадварыг үнэлэх, дүгнэх
4. Ур чадварын нэмэгдэл олгох
5. Бусад

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Хариуцагч	Журмын код
1		М.Мөнгөнцэцэг	Ж-МУМАГҮУЧНОЖ-03

Баримт бичгийн түгээлт буюу байвал зохих байрлал

Баримт бичгийн төлөв	Байрлал	Тайлбар
Эх хувь:	Архив, бичиг хэрэг, захирлын туслах	
Хяналттай хувь:	1	
Хүчингүй хувь:	2	

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар байгууллагын ажилчдын ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг дэмжиж, ур чадварын нэмэгдэл олгох, түүнд тавигдах шалгуур тогтоох, үнэлж дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Ур чадварын нэмэгдэл олгохтой холбоотой энэхүү журмаар зохицуулаагүй харилцааг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын тогтоол болон түүнд нийцүүлэн гаргасан бусад акт, баримт бичигт үндэслэн шийдвэрлэнэ.
- 1.3 Ажилчдын ур чадварыг үнэлж дүгнэх ажиллагаа нээлттэй, ил тод, шударга байх зарчид тулгуурлана.
- 1.4 Энэхүү журамд заасан шалгуурыг хангасан, ёс зүйн зөрчилгүй, сахилгын шийтгэлгүй ажилтанд ур чадварын нэмэгдэл олгогдоно.
- 1.5 Ур чадварын нэмэгдлийг албан хаагчийн зөвхөн ур чадвар, шалгуурт үндэслэн олгоно.

ХОЁР. УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

2.1 Ажилчдыг дараах шалгуур үзүүлэлтүүдээр тус бүр үнэлнэ. Үүнд:

2.2.1 Байгууллагын удирдах (музейн захирал болон нэгжийн дарга нар буюу ТҮСБ-5, ТҮСБ-6, ТҮСБ-7 зэрэглэлд хамаарах удирдах) албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Манлайлах чадвар	Ажилтны үр бүтээлтэй ажиллах орчин нөхцөл, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал	10	50
		Үйлчлүүлэгчийн тав тух, соёлын хүртээмж орон зай, уран бүтээлийн чанар, сэтгэл ханамжийг бүрдүүлсэн байдал	10	
		Авьяас билэг, ур чадвар, мэргэжлийн туршлагаар манлайлсан байдал	10	
		Хамт олны төлөвшил, байгууллагын соёлд гарсан өөрчлөлт	10	
		Төсөв, санхүү, эд хөрөнгийн зөрчилгүй байх	10	
2	Мэргэжил, арга зүйн чадвар	Мэдлэг, туршлагаа хуваалцах чадвар	10	30
		Ажилтны мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт	10	
		Эрхэлсэн ажил үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байдал	10	
3	Ажлын арга барил, асуудал шийдэрлэх чадвар	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, асуудал шийдвэрлэсэн байдал	10	20
		Соёлын үйлчилгээний хүртээмжид гарсан ахиц, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл	10	

2.2.2 Байгууллагын удирдах (ТҮСБ-5, ТҮСБ-6, ТҮСБ-7 зэрэглэлд хамаарах удирдах) албан тушаал

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Манлайлах чадвар	Авьяас билэг, ур чадвар, мэргэжлийн туршлагаар манлайлсан байдал	10	50
		Хариуцсан ажлаа цаг үеийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн гүйцэтгэсэн байдал	10	
		Соёлын үйл ажиллагааны чиглэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байдал, үр дүн	10	
		Хамт олны дунд хүлээн зөвшөөрөгдсөн байдал	10	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	10	
2	Мэргэжил, арга зүйн чадвар	Бүтээлч байдал, шинэлэг санал, санаачилга гаргасан байдал, хэрэгжилт, үр дүн	10	30
		Ажилтны мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт	10	
		Соёл, урлаг, уран бүтээлийн эрхэлсэн ажил үүргээ мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн байдал	10	
3	Ажлын арга барил, асуудал шийдэрлэх чадвар	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, асуудал шийдвэрлэсэн байдал	10	20
		Соёлын үйлчилгээний хүртээмжид гарсан ахиц, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл	10	

2.2.3 Байгууллагын гүйцэтгэх (ТҮСБ-2, ТҮСБ-3, ТҮСБ-4, ТҮСБ-5, ТҮСБ-6 зэрэглэлд хамаарах) албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Авьяас билэг, мэргэжлийн ур чадвар, туршлагаа хөгжүүлсэн байдал	15	60
		Өөрийн туршлага, мэдлэг чадвараар бусдад үлгэрлэн, түгээсэн байдал	15	
		Бүтээлч, шинэлэг санаачилга гаргасан байдал, хэрэгжилт, үр дүн	15	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	15	
2	Ажлын арга барил	Шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, асуудал шийдвэрлэсэн байдал (үйлчлүүлэгч, эрдэмтэн судлаачийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан байх)	10	40
		Ажлын гүйцэтгэлд гарсан ахиц, үр дүн	10	
		Соёл урлагийн орчин бүрдүүлэхэд үзүүлсэн бүтээлч байдал, иргэдэд үзүүлсэн төрийн үйлчилгээ	10	
		Хамт олны дунд хүлээн зөвшөөрөгдсөн байдал	10	

2.2.4 Байгууллагын үйлчилгээний (ТҮСБ-1, ТҮСБ-2 зэрэглэлд хамаарах туслах) албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Албан тушаалын чиг үүргээ чанартай, үр бүтээлтэй гүйцэтгэсэн байдал	25	100
		Соёл урлагийн орчин бүрдүүлэхэд үзүүлсэн бүтээлч байдал, иргэдэд үзүүлсэн төрийн үйлчилгээний чанар, хүртээмж	25	
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	25	
		Өөрийн хариуцаж буй техник, хэрэгслийн бүрэн бүтэн байдал	25	

2.2.5 Байгууллагын Ерөнхий нягтлан бодогч ТҮМ-8, Нягтлан бодогч ТҮМ-6, Нярав ТҮМ-4 албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Улирал, жилийн тайлан тэнцэл, төсвийн төслийг хугацаанд нь үнэн зөв гаргасан байх	25	100
		Анхан шатны бүртгэлийн хөтлөлт, баримтын боловсруулалтыг тухай бүрт нь хийж, данс бүртгэлд тусгасан байх	25	
		Хөрөнгийн зарцуулалтад тогтмол хяналт тавьж, батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байх	25	
		Өр, авлагын барагдуулалтын байдал	25	

2.2.6 Байгууллагын хүний нөөцийн ажилтан ТҮ-7 албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Ажилтан нарын хувийн хэргийг тухай бүрд нь нээж, баяжилтыг зохих журмын дагуу хийсэн байх	33.3	100
		Ажиллагсдын цалин хөлс, нэмэгдэлтэй холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр авч байх	33.3	
		Ажилтан нарын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх талаар идэвх санаачилгатай ажиллаж, үр дүнд хүрсэн байдал	33.4	

2.2.7 Байгууллагын бичиг хэргийн эрхлэгч ТҮМ-3 албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Бичиг хэргийг эмх цэгцтэй хөтөлж, архивын бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалж, хамгаалах	25	100
		Гаднаас ирсэн болон гадагшаа явуулж байгаа бичиг, хариутай бичгийн гүйцэтгэлд хяналт тавих	25	
		Бичээч нарын ажилд байнга хяналт тавьж байх	25	
		Өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр хөнгөн шуурхай чанартай гүйцэтгэж байх	25	

2.2.8 Байгууллагын цахилгаанчин ТҮ-3, мужаан ТҮ-3, сантехникч ТҮ-3 албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Эрхэлсэн ажлын чиглэлээр хариуцсан тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангаж засвар үйлчилгээг хугацаанд нь чанартай гүйцэтгэдэг байх	50	100
		Гарсан эвдрэл, гэмтлийг түргэн шуурхай, чанартай засварлах	50	

2.2.9 Байгууллагын жолооч ТҮ-3 албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Өөрийн хариуцаж байгаа машин техникийг ариг гамтай эдэлж, техникийн үйлчилгээг тогтмол хийж байх	33.3	100
		Машин, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, бэлэн байдалд байлгасан байх	33.3	
		Шатахуун, тослох материалыг нормын дагуу хэмнэлттэй зарцуулж, тооцоог санхүүтэй тогтоосон хугацаанд хийж, замын хуудсыг зохих журмын дагуу хөтөлж байх	33.4	

2.2.10 Байгууллагын харуул ТҮ-1, үйлчлэгч ТҮ-1 албан тушаалтан

№	Шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээ оноо	Нийт үнэлгээ
1	Ажил гүйцэтгэх чадвар	Ажлын байрны эмх цэгц нь үлгэр жишээ байж, ариун цэврийн шаардлага хангасан байх	33.3	100
		Эрхэлсэн ажлын чиглэлээр зөрчил, доголдол гаргаагүй байх	33.3	
		Байгууллагын доторх эд хогшлыг байнга цэвэр үзэмжтэй байлгаж, бүрэн бүтэн байдлыг хангасан байдал	33.4	

ГУРАВ. УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ

- 3.1 Ажилчдын ур чадварыг энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлж дүгнэх бөгөөд нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох эсэх асуудлыг Захиргааны зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн Захирал шийдвэрлэнэ.
- 3.2 Захиргааны зөвлөлийн энэхүү журмын 3.1-д заасан санал, дүгнэлт гаргах ажиллагаанд алба, төвийн дарга нар өөрийн харьяалах нэгжийн ажилчдын ур чадварын үнэлгээний талаарх саналаа тус тус хүргүүлж ажиллана.

ДӨРӨВ. УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ

- 4.1 Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан ажилтанд байгууллагын жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно.
- 4.2 Ажилчдын ур чадварын нэмэгдлийг тухайн улирлын сүүлийн сарын 20-ны дотор үнэлсэн үнэлгээнд үндэслэн дараагийн улирлын нэмэгдлийг сар бүр олгоно.
- 4.3 Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш үнэлгээ авсан ажилтанд албан тушаалын сарын үндсэн цалингийн 10-25 хувиар тооцож, нэмэгдлийг дараах хувиар тогтооно.

60-69 оноо	70-79 оноо	80-89 оноо	90-100 оноо
10%	15%	20%	25%

- 4.4 Ажилтан ур чадварын нэмэгдэл олгох үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дээд шатны удирдлагад гомдол гарган шийдвэрлүүлэх эрхтэй.

ТАВ. БУСАД

- 5.1 Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 5.2 Энэ журмыг батлах эрх зүйн үндэслэл болж буй хууль тогтоомж өөрчлөгдсөн, дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтны шийдвэр гарсан бол тухайн хууль тогтоомж, шийдвэрт нийцүүлэн энэхүү журамд өөрчлөлт оруулна.

---oOo---